



“ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЛИЙН ТҮҮВЭР”

Монгол Улсын ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэн, БНХАУ-ын Өвөр Монголын Зүүн Хойт Ази Судлалын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудын бичсэн хамтын бүтээлийг 2004 онд Хөх хотод хятад, монгол хэлээр орчуулан хэвлэсэн юм.

Энэхүү хамтын бүтээлд хоёр хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын 12 өгүүлэл багтжээ. Өгүүллүүдийн товч агуулга нь Монгол Улс ба Зүүн Хойт Азийн орнуудын хооронд аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж, хөгжлийн ази “загвар” гэж юу болох, уул уурхайн салбар дахь Монгол-Хятадын харилцааны өнөөгийн байдал, хэтийн төлөв, БНХАУ-ын баруун бүс нутгийг хөгжүүлэх бодлого стратеги манай улсын эдийн засгийн хөгжилд нөлөөлөх боломж, худалдааны чөлөөт бүс, Монгол-Хятадын хамтарсан жижиг дунд үйлдвэрийн өнөөгийн байдал, хилийн худалдаа түүний ач холбогдол, Монгол Улс, Өвөр Монголын хоорондын соёлын харилцааны түүх, хөгжил зэрэг сэдвээс бүрдэж байна.